

**2.1.26 “ЭРДЭНЭ БАГ. 6 ДУГААР ГУДАМЖИНД ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙ
ШИНЭЭР БАЙГУУЛАХ” АЖЛЫН ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН
ГЭРЭЭ**

БӨ-06/23

Орхон аймаг

Нэг талаас Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн /цаашид “захиалагч” гэх/, нөгөө талаас “Алист констракшн” ХХК-ийн захирал Ш.Мөнхсайхан /цаашид “гүйцэтгэгч” гэх/-тэй дараах зүйлийг харилцан тохиролцож Иргэний хуулийн 476-482 дугаар зүйлийг удирдлага болгон энэхүү гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулав.

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбоотой захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь “Эрдэнэ баг. 6 дугаар гудамжинд хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах” ажлыг БӨ-06/23 тоот гэрээгээр /цаашид “ажил” гэх/ 95 430 700 /ерэн таван сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун/ төгрөгөөр /цаашид “гэрээний үнэ” гэх/ гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын төсөв нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3 Гэрээний нийт дүн 95 430 700 /ерэн таван сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун/ төгрөг. Үнээс /орон нутгийн хөгжлийн сан/-ийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 95 430 700 /ерэн таван сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун/ төгрөг /цаашид гэрээний үнэ гэх/ бөгөөд үүнээс захиалагчийн хяналтын зардал 1 610 188 /нэг сая зургаан зуун арван мянга нэг зуун наян найман/ төгрөг, зураг төслийн зардал 2 700 000 /хоёр сая долоон зуун мянган/ төгрөг, зохиогчийн хяналтын 805 094 /найман зуун таван мянга ерэн дөрвөн/ төгрөгийг хасаж гүйцэтгэгчийг 90 315 418 /ерэн сая гурван зуун арван таван мянга дөрвөн зуун арван найман/ төгрөгөөс ажлын явцад захиалагчийн хянаж баталгаажуулсан гүйцэтгэлийг үндэслэн гэрээний үнийн дүнгийн 80% хүртэл үе шатны санхүүжилтийг олгож, үлдэгдэл санхүүжилтийг ажлыг ашиглалтад хүлээн авсан комиссын акт, захиалагчийн хянаж баталгаажуулсан гүйцэтгэл, туршилт болон ил, далд ажлын акт холбогдох баримт бичгийг үндэслэж олгоно. Үүнээс магадлашгүй ажлын зардал 1 610 188 /нэг сая зургаан зуун арван мянга нэг зуун наян найман/төгрөгийг захиалагчийн шийдвэрээр зарцуулна.

1.4 Санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжилүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

1.6 Урьдчилгаа төлбөрийн банкны баталгаа болон барилгын ажлын гүйцэтгэлийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд санхүүжилтийг зогсоож, захиалагч гэрээг цуцлан хариуцлага тооцуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

1.7 Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.8 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзодуулсан энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдолыг өөрийн хөрөнгөөр арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Зөрчил, доголдлыг арилгуулахаар тогтоосон хугацаанд гүйцэтгэгч ямар нэгэн арга хэмжээ аваагүй бол захиалагч уг доголдлыг арилгаж, түүнтэй холбогдон гарсан зардлыг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлнэ.

1.9 Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгасан нөхцөл байдлыг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хүлээнэ.

1.10 Төсвийн орлого бүрдэлт, эх үүсвэр хүрэлцээгүйгээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг журамд заасан хугацаанд гүйцэтгэлээр санхүүжүүлэх боломжгүй нөхцөл үүсвэл эх үүсвэрийн бүрдэл (төсвийн орлого)-тэй уялдуулан санхүүжүүлнэ.

1.11 Гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн албан бичгээр харилцана.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Гүйцэтгэгч Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт байршилтай “Эрдэнэ баг. 6 дугаар гудамжинд хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах” ажлыг хуанлийн 30 хоногт ашиглалтад оруулна. /Уг хугацаанаас бүх нийтээр амрах өдрүүдийг хасаж тоолно¹/

2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа 2023 оны 6 сарын 02-ны өдрөөс 2023 оны 07 сарын 02 өдөр хүртэл

2.2 Ажил эхлэх хугацаа 2023 оны 06-р сарын 02-ны/ний/ өдөр

2.3 Ажил дуусах хугацаа 2023 оны 07-р сарын 02-ны/ний/ өдөр

2.4 Гэрээг батлагдсаны дараа ажил эхлүүлэх зөвшөөрөл /Гэрээ батлагдсан өдөр гэдгийг аймгийн Засаг дарга гарын үсэг зурсан өдрийг ойлгоно/ олгоно.

2.5 Гэрээнд хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ БАРИМТ БИЧИГ

3.1 Дор дурдсан баримт бичгүүд нь гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

3.1.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл 01/242, 2023.03.01

3.1.2 Үнийн санал;

3.1.3 Гэрээний ерөнхий нөхцөл;

3.1.4 Гэрээний тусгай нөхцөл;

3.1.5 Техникийн тодорхойлолт;

3.1.6 Зураг ХББЗА-68/2022, Төсөв БЗА-52/2022

3.1.7 Гүйцэтгэгчээс ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;

3.1.8 Ажил гүйцэтгэх хуваарь;

3.1.9 Бусад шаардлагатай баримт бичиг;

3.2 Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

4.1 Захиалагч Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн

4.2 Төслийн менежер: “ХББЗА” ОНӨААТҮГ-ЫН Хяналтын инженер Б.Чингис, Захиргааны 3-р байр, 210 тоот, утас: 99897375

4.3 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Эрдэнэ баг. 6 дугаар гудамжинд хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах”, /БӨ-06/23/

4.4 Ажлын талбай: Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах ба ажлын талбайн зохион байгуулалтын схем

4.5 Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр: Ажлын талбайн баримт бичиг бүрдэж ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ гарсан өдрөөс эхэлнэ.

4.6 Гүйцэтгэгч нь гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргаж, гэрээ байгуулна. Уг хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын хөтөлбөрийг ирүүлээгүй, гэрээ байгуулаагүй бол ажил гүйцэтгэхээс татгалзсан гэж үзэж гэрээ байгуулахгүй бөгөөд дахин сонгон шалгаруулалт явуулна. /хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийг Иргэний хуульд тайлбарласнаар ойлгоно/

4.7 Ажлын хөтөлбөрийг хуанлийн /7/ хоног тутам тодотгоно.

4.8 Чанарын баталгаат хугацаа: Монгол улсын Барилгын тухай хуулийн 14.3 /Барилга байгууламжийг ашиглалтанд зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/, 14.6 /энэ хуулийн

14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолтын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна./

4.9 Барилгын тухай хуулийн 14.8 дах заалтын дагуу барьцаа хөрөнгө 5 хувь байна. Барьцаа хөрөнгийг Барилгын тухай хуулийн 14.3, 14.4, 14.5 заасны дагуу үргийн биелэлтийг дүгнэж олгоно.

4.10 Ажлын гүйцэтгэлийн төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 90 хоног байна.

ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Ажлын зураг төслийг гэрээ батлагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор гүйцэтгэгчид хүлээлгэж өгнө

5.2 Ажлын явц, чанар, гүйцэтгэлд үе шатны хяналт тогтмол тавьж, талбайн журналд тэмдэглэл хөтлөн, фото зургаар баримтжуулан, ил далд ажлын актыг хянан баталгаажуулна.

5.3 Далд ажлыг далдлах талаар гүйцэтгэгчээс бичгээр өгсөн мэдэгдлийг бүртгэж авснаас хойш ажлын 3 хоногийн дотор захиалагч үзээгүй бол гүйцэтгэгч ажлыг үргэлжлүүлэх бөгөөд ажил далдлагдсаны дараа дахин үзэх шаардлага гарсан тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг захиалагч хариуцна.

5.4 Зураг төслийн норм болон барилгын ажлын технологи зөрчигдсөн, чанарын гологдол гаргасан, тээвэр механизмын үнийн зөрүүг буруу тооцсон нөхцөлд захиалагч эрх бүхий байгууллагаар экспертиз хийлгэх, торгууль ногдуулах, ажлыг зогсоох, гүйцэтгэгчийг солих, гарсан зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх эрх эдлэнэ.

5.5 Ажлын талбайг ашиглаж эхлэхээс өмнө ажлын талбайг бүрэн чөлөөлж өгнө.

5.6 Ажлыг гүйцэтгэх хугацаанд барилгын норм, дүрэм стандарт, ажлын зураг төсвийг ноцтой зөрчсөн, тухайн ажлын санхүүжилтийг өөр зориулалтаар ашигласан, гэрээт хугацаанд ажлыг гүйцэтгээгүй зэрэг зөрчлүүд нь баримтаар нотлогдвол захиалагч гэрээг цуцалж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

5.7 Ажлын үе шат бүрт гүйцэтгэгч байгууллагатай хамтран зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд дүгнэлт гаргуулж ажиллана.

5.8 Гэрээнд заасан хугацаанд ажил эхлүүлэх болон үргэжлүүлэх зөвшөөрөл аваагүй ажлын зураг төсөвт дур мэдэн өөрчлөлт оруулсан бол Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2, 3-т заасны дагуу арга хэмжээ тооцно.

5.9 Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлж, хууль зөрчихгүй байх, авлигаас ангид ажиллах үүрэг хүлээнэ.

5.10 Захиалагчийг төлөөлөгч ажлын явцад зөрчил, БНБД болон стандартад нийцээгүй байж болзошгүй аливаа ажилд зөрчил, ил далд ажлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгнө.

5.11 Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт гэрээнд заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, гарсан зөрчлийг арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид хүргүүлнэ.

ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ, ЭРХ

6.1 Гэрээ батлагдсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан ажил эхлүүлэх зөвшөөрлийг авсан байна. /Гэрээ батлагдсан өдөр гэдгийг аймгийн Засаг дарга гарын үсэг зурсан өдрийг ойлгоно/

6.2 Ажлыг батлагдсан зураг төсөл, техникийн норм дүрмийн дагуу захиалагчийн буюу төсөвт заасан материалыар чанартай гүйцэтгэж, өөрийн угсарсан тоног төхөөрөмжийн

туршилтыг захиалагчийн хяналтын дор хийж баталгаажуулна. Далд ажлыг далдлах, туршилт, тохирулга хийх зэрэгт захиалагчид заавал бичгээр мэдэгдэнэ.

6.3 Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй 1-ээс доошгүй иргэнийг зохих журмын дагуу үндсэн болон туслах ажилтнаар авч ажиллуулах ба хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд сахиж ажиллана.

6.4 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхдээ туслан гүйцэтгэгч оролцуулсан бол энэхүү гэрээний нөхцөлийн дагуу гэрээ байгуулах ба ажлын үр дүнг зөвхөн ерөнхий гүйцэтгэгч өөрөө захиалагчийн өмнө хариуцна.

6.5 Энэхүү гэрээгээр тохирсон үнэ нь эцсийн үнэ байх бөгөөд барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жинхэнэ өртөг нь хэтэрсэн нөхцөлд дутагдах хөрөнгийг гүйцэтгэгч өөрөө хариуцан санхүүжүүлнэ. /Суурь үнэ албан ёсоор өөрчлөгдсөн буюу байгалийн болон гэнэтийн осол үүнд хамаарахгүй/

6.6 Барилгын тухай хуулийн 13.1.3, 40.1.11, 40.1.12-т зааснаар барилгын ажил гүйцэтгэх материал түүхий эд, барилга байгууламжийн хийц, бүтээцийн эдлэлийн чанарт аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын итгэмжлэгдсэн лабораториор сорилт, шинжилгээг хийлгэж дүгнэлт гаргуулна.

6.7 Туршилт тохирулга хийх, ажлын явцад илэрсэн зөрчлийг арилгах буруу, дутуу хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр тухай бүр нөхөн гүйцэтгэж, захиалагчаас тогтоосон хугацаанд дуусгаж захиалагчид хүлээлгэн өгнө.

6.8 Гэрээнд заагдсан ажлаа чанартай хугацаандаа гүйцэтгэсэн тохиолдолд ажил гүйцэтгэлийн зардлыг шаардаж авах эрхтэй.

6.9 Гүйцэтгэгч нь гэрээ батлагдсанаас хойш З хоногийн дотор ажлын талбайд мэдээллийн самбарыг олон нийтэд харагдахуйц газар ил байрлуулсан байна.

6.10 Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, талбайн зохион байгуулалтын зураг төслийг зурж батлуулан мөрдөж ажиллах, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.

6.11 Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, барилга угсралтын ашиглагдахгүй болсон техник хэрэгсэл эд зүйл, тоног төхөөрөмжийг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.

6.12 Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.

6.13 Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, БНБД болон стандарт шаардлагад нийцсэн байна.

6.14 Гүйцэтгэгч гарсан зөрчлийг арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.

6.15 Ажил хүлээн авсан баримт /акт/ үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, ил далд ажлын доголдол түүний улмаас үссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

6.16 Гэрээний нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат 10 сая төгрөгнөөс дээш зарлага, санхүүжилтийн мэдээллийг улирал бүр шилэн дансны цахим хуудсанд хавсралт 19 дүгээр маягтын дагуу мэдээлэх.

6.17 Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлж, хууль зөрчихгүй байх, авлигаас ангид ажиллах үүрэгтэй.

6.18 Барилгын тухай хуулийн 40.1.3-д заасны дагуу барилга байгууламжийг давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй. Үүргээ биелүүлээгүйгээс үссэн хохирлыг захиалагч хариуцахгүй.

ДОЛОО.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАХ

7.1 Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

7.1.1 Ажлын гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үссэн болохыг гүйцэтгэгч нотолсон.

7.1.2 холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал

7.2 Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг гэрээний хугацаа дуусахаас ажлын 5 хоногт холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.

7.3 Гэрээний 2.1-д заасан хугацаа хэтрүүлсэн эсхүл гэрээний 7.3-д заасан хугацаанд хугацаа сунгуулах хүсэлтээ өгч сунгуулаагүй бол хэтэрсэн хоног тутам гэрээний нийт үнийн дүнгийн 0,5%-иар алданги тооцож сутгана. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй.

НАЙМ.ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

8.1 Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл / эс үйлдэхгүй/-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол /хүний амь нас, эрүүл мэнд/ учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.

8.2 Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл /эс үйлдэхгүй/-н улмаас эдийн болон эдийн бус хохирол /хүний амь нас, эрүүл мэнд/ учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.

ЕС. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

9.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл /гал түймэр, үер, газар хөдлөлт, дайны байдал зэрэг/-ийн улмаас гэрээний гүйцэтгэлд шуд нөлөөлсөн бол талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгднө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдох ба эрх бүхий байгууллагын дүгнэлтэд үндэслэнэ.

9.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал энэ тухайгаа уг нөхцөл байдал үссэнээс хойш 10 хоногийн дотор нөгөө талд бичгээр мэдэгдэж гэрээг гүйцэтгэх хугацааг сунгана. Заасан хугацаанд нөгөө талдаа мэдэгдээгүй бол гэрээ сунгах үндэслэл болохгүй.

9.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нь 6 сараас дээш хугацаагаар үргэлжлэхээр байвал талууд энэхүү гэрээг бүрэн болон хэсэгчлэн цуцлах эрхтэй. Энэ тохиолдолд аль нэг тал нь нөгөө талаасаа хохирол нэхэмжлэх эрхгүй.

АРАВ.ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХҮЙ

10.1 Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.

10.2 Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.

10.3 Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.

10.4 Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

10.5 Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.

10.6 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.

10.7 Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

АРВАН НЭГ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

11.1 Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцлаж болно:

11.1.1 Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 10 хоног ажлын талбайг орхисон.

11.1.2 Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч ажлын чанар үр дүнд муугаар нөлөөлсөн, үр дүн гараагүй.

11.1.3 ГТН-д заасан алдангийн нийт үнийн дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүн 50%-иас хэтэрсэн.

11.1.4 Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, гэрээгээр хүлээсэн ажил үүргийг гүйцэтгэх явцад гэрээний үүргийг ноцтой зөрчсөн.

11.1.5 Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч, цаашид сунгагдахгүй болсон, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.

11.1.6 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд ажлыг БНbd болон стандартын шаардлага хангахгүй, бүрэн гүйцэтгээгүй тохиолдолд захиалагчийн санаачлагаар цуцлаж болно.

11.2. Талууд гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнээс хойш хуанлийн 10 хоногийн дотор гэрээ цуцлах мэдэгдлийг нөгөө талд бичгээр гаргана.

11.3. Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авсан тал хуанлийн 10 хоногийн дотор хариуг албан бичгээр өгөх ба хариу ирүүлээгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцон гэрээг цуцлана.

АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

12.1 Энэхүү гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэж, энэхүү гэрээний талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

12.2 Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугцаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.

12.3 Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

12.4 Захиалагч төслийг үндэслэн гэрээнд заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.

12.5 Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн аллдаа гарсан, гэрээний хугцаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.

12.6 Ажлын бүрдэл хэсгийг өмчлөх явцад зураг төслийг өмчлөх эрх зэрэг оюуны өмчийн эрх нь зөрчигдсөн талаар гуравдагч этгээд захиалагчид гомдол гаргасан тохиолдолд уг гомдлыг ажил гүйцэтгэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

12.7 Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт [ажлын үе шат бурд баталгаажуулна] болон ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [ашиглалтанд хүлээлгэн өгөхөөс 3 хоногийн өмнө]-ны дотор гаргаж өгнө.

12.8 Дээрх материалыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0.01 хувиар бодож алданги тооцно.

12.9 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтанд авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

12.10 Гэрээг 6 хувь үйлдэж, Орон нутгийн өмчийн газар, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Аймгийн төв архив, "ХББЗА" ОНӨААТҮГ, гүйцэтгэгчид нэг нэг хувь хадгалагдана.

АРВАН ГУРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

13.1 Энэхүү гэрээний харилцаатай холбоотой аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжоор зохицуулж, тайлбарлана.

13.2 Энэхүү гэрээнээс болон түүнтэй холбогдож үүсч болох бүх маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэлцэл үр дүнгүй тохиолдолд талууд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

2.1.26 “ЭРДЭНЭ БАГ. 6 ДУГААР ГУДАМЖИНД ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙ ШИНЭЭР БАЙГУУЛАХ” АЖЛЫН ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

Захиалагч:

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Оюут баг, Захиргааны II-р байр



“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-ын Захирал

Ц.ВАЯРЖАРГАЛ
2023 оны 01 сарын 03-өдөр

“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-ын Хяналтын инженер

Б.ЧИНГИС
Утас:99897375

“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-ын Няглан бодогч

Т.ГАНБОЛД
Утас:99350848

“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-ын Эрх зүйч, гэрээний ажилтан

Д.ОЮУН-ЭРДЭНЭ
Утас:95775549

Гүйцэтгэгч:

Хаяг: Орхон аймаг Баян-Өндөр сум Бүрэнбүст баг 5-13-69 тоот

Данс: 5001307910 /Хас банк/



БАТЛАВ: "ХОТ БАЙУУЛАН ЕАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА" ОНӨААТУГ-ИЙН
ЗАХИРАЛ

8107149 2021030033
ХАМГИУУЛСАН ДАТА: 2021-03-03

Гэрээнд агуулар: БФ-06/23
Эрдэнэ баг 6-р гудамжинд хүхдийн тоглоомын талбай шинээр байгуулах ажлын хуваврьс
/Хувьнын 30 хоног/



Гэрээнд агуулар: БФ-06/23

Эхлэх /огноо/: 2023.06.02
Дуусах /огноо/: 2023.07.02

№	Ажлын нэр	Ажлын хувь	6 сар		7 сар	
			Хэмжих нэгж	Тоо хэмжээ	2 хоног	2 хоног
A			2	3	4.0	
1	Газрын ажил	М3	2	1.5%		
2	Бетон талбайн ажил	М3	0.06	30.6%		
3	Ялан замын ажил	М3	7.68	3.4%		
4	Тоглоом уграх ажил	М3	0.128	30.6%		
5	Тогижилтэн ажил	М3	0.72	4.7%		
6	Элчиний талбайн ажил	ТН	0.198	2.6%		
7	Сэргэсэн талбайн хувьны ажил	ТН	0.786	23.6%		
8	Дүүжин сандал уграх ажил	ТН	0.11	3.0%		
9	Комисс ажилтуулэх			100.0%		

Зөвшөөрсөн: ХББЗА ОНӨААТУГ-ЫН

Ерөнхий инженер

Ц.Хишигжаргал

График боловсруулсан: АлисТ Констракшн ХХК-ИЙН

Ерөнхий инженер Р. Ган-Эрдэнэ

Р. Ган-Эрдэнэ

Хянасан: ХББЗА ОНӨААТУГ-ЫН

Хяналтын инженер

Б. Чингис